



# **УВС ХҮНС**

Эрүүл хүнс аз жаргалын эхлэл

## **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Улаангом хот  
2024 оны 04 сар

## 1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ГУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2 –оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

## 2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ГУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ГУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>71</b>		<b>98,1%</b>

## 3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- 3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

#### 4. Үнэлгээний асуулга

#### “УВС ХҮНС” ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журамтай, Залгамж холбооны бодлогод тусгасан	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж ажилладаг	2	100%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Дотоод аудитын хороо, Цалин урамшууллын хорооны бодлогын баримт бичигтэй	2	100%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр тогтмол ханган, компанийн засаглалын сургалтад хамруулдаг	2	100%

6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу хариуцлага хүлээдэг	2	100%
<b>ДҮН</b>				12	100%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн дүрмээр ТУЗ нь 1/3-с дээш хараат бус гишүүнтэй байхаар зохицуулсан. Одоогийн байдлаар ТУЗ 9 гишүүнтэй, үүний 3 нь хараат бус гишүүн байна	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Биелүүлж ажилладаг	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн. Аудитын хорооны үйл ажиллагааг Дотоод хяналтын журмаар зохицуулдаг	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Биелүүлж ажилладаг	Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд тухайн хорооны үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журмаар зохицуулагддаг	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Биелүүлж ажилладаг	Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмаар үйл ажиллагааг зохицуулдаг. Залгамж халааны бодлогын баримт бичгийг 2023 онд боловсруулсан.	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохицуулсан тус бүр бодлогын баримт бичиг, журамтай	2	100%
<b>ДҮН</b>				10	100%

<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан "Увс Хүнс" ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам"-тай ба хагас жил болон жилийн эцсийн тайлан бусад мэдээ мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар мэдээлдэг	2	100%
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Биелүүлж ажилладаг	ТУЗ болон ХЭХ-ийн хурлаас гарсан шийдвэр, компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нийтэд ил тод нээлттэй байхыг зорьж ажилладаг. Цаашид мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх сувгийг өргөжүүлэн ажиллана.	2	100%
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд боловч болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу тайлагнадаг бөгөөд КЗК-ийн хүрээнд хагас жил болон бүтэн жилээр үйл ажиллагааны тайланг бэлтгэн олон нийтэд мэдээлдэг	2	100%
<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>100%</b>
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг	Аудитын хорооны үйл ажиллагааг хөндлөнгийн аудитортой харьцах, хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар Аудитын хорооны үйл ажиллагааны журамд тусгаж өгсөн ба энэхүү журмын дагуу үйл ажиллагааг явуулдаг	2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Цаашид хэрэгжүүлж ажиллана	2024 онд зохион байгуулагдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас эхлэн хэрэгжүүлж ажиллана.	1	50%

17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд мэдээ мэдээллийг оруулан өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг	2	100%
<b>ДҮН</b>				5	83%
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон компайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь эрсдэлийн удирдлагын бодлоготой бөгөөд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажилладаг	2	100%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн үйл ажиллагааг хянан ажилладаг. 2023 онд эрсдэлийн удирдлагын хороог байгуулан ажиллах журам баталсан.	2	100%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн үйл ажиллагаанд гадаад болон дотоод эрсдэлийг тооцон эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан эрсдэлийг бууруулж хяналт тавин ажилладаг	2	100%
21	<i>5.4. Компани нь компайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг	Компайнсын бодлогын баримт бичигтэй ба үйл ажиллагааг тухайн баримт бичгийн хүрээнд явуулдаг. Компайнсын нэгж ажилтан томилон ажиллаж байна.	2	100%
<b>ДҮН</b>				8	100%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>					
<b>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</b>					

22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Биелүүлж ажилладаг	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хорооны ажиллах журмын хүрээнд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг хэлэлцэн олгодог	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь ажлыг гүйцэтгэлийг үнэлэх журамтай бөгөөд журмын дагуу эдгээр үйл ажиллагааг зохицуулан ажилладаг	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Биелүүлж ажилладаг	Компанийн шагнал урамшууллын журмыг 2023 онд Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам шинэчлэн батлан тусган ажиллаж байна	2	100%
ДҮН				6	100%

**ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**  
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

25	<i>7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь Харилцаа холбоо, оролцоо хэлэлцүүлгийн журамтай бөгөөд журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажилладаг. 2023 онд хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр боловсруулсан	2	100%
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Биелүүлж ажилладаг	Үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан мэдээ, мэдээллийг тусган тайлагнадаг	2	100%
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Биелүүлж ажилладаг	Компани өөрийн цахим хуудсанд мэдээ мэдээллийг байршуулдаг ба оролцогч талуудтай мэдээллийг албан и-мэйлээр мөн солилцдог	2	100%
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журамтай бөгөөд журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажилладаг	2	100%
ДҮН				8	100%

**НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**

**ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь батлагдсан ёс зүйн журамтай.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь батлагдсан ёс зүйн журамтай ба мөн комплайнсын бодлогод шүгэл үлээгчийн тогтолцооны талаар тусгаж өгсөн. Дээрх баримт бичгийн хүрээнд үйл ажиллагааг зохицуулан ажилладаг.	2	100%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Биелүүлж ажилладаг	Ёс зүйн журам болон комплайнсын бодлогод тусгасан. Дээрх баримт бичгийн хүрээнд үйл ажиллагааг зохицуулан ажилладаг	2	100%
<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>100%</b>

**ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**

**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь өөрийн цахим хуудсаар үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд мэдээллэн ажилладаг. Мөн хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг МХБ-ийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг	2	100%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	Биелүүлж ажилладаг	Компани нь <a href="http://www.uvskhuns.mn">www.uvskhuns.mn</a> цахим хуудас болон Увс Хүнс ХК/ Uvskhuns JSC сошиал сүлжээний хуудас, <a href="mailto:info@uvskhuns.mn">info@uvskhuns.mn</a> албан и-мэйл хаягаар дамжуулан мэдээлэл олон нийтэд хүргэх болон мэдээлэл солилцон ажилладаг. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр боловсруулан ажилласан	2	100%



34	<b>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b>	Биелүүлж ажилладаг	Компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр заасан хугацаанд зохицуулах байгууллагуудын холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулдаг	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b>	Биелүүлж ажилладаг	Компани нь эдгээр үйл ажиллагаанд санал өгөх эрхийг ХЭХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг	2	100%
36	<b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зорчигдохөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b>	Биелүүлж ажилладаг	Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор компанийн дүрэмд тусган хэрэгжүүлж ажилладаг. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг 2023 онд боловсруулсан	2	100%
<b>ДҮН</b>				10	100%
<b>НЭГДСЭН ДҮН</b>				71	98,1%

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Улаангом сум

“Увс Хүнс” ХК нь засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль, дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган салбартаа тэргүүлэгч компаниудын нэг болохыг зорин ажиллаж байгаа билээ.

2022 онд шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийг 2023 оны байдлаар 3 дахь удаа үнэлэхэд өмнөх оныхоос 8,1%-иар өссөн үзүүлэлттэй буюу 98,1% засаглал хэвийн эрсдэлгүй гэсэн үр дүн гарлаа.

2022 оны үнэлгээний үр дүнг үндэслэн 2023 онд засаглалын тогтолцоонд дараах ажлыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1. Бодлого, журмыг шинэчлэн сайжруулах
  - Залгамж халааны бодлогын баримт бичиг боловсруулан ажиллах
  - Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр боловсруулан ажиллах
  - Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх журам боловсруулах ажиллах
2. Үйл ажиллагааны чиглэлээр
  - Эрсдэлийн удирдлагын хороо байгуулан ажиллах
  - Комплайнсын нэгж, ажилтан томилон ажиллуулах
3. Үйл ажиллагааны тайлангийн чиглэлээр
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага, ажилласан жил, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээг тодорхой тусгаж оруулах
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тусгах

### 2023 онд төлөвлөсний дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангийн хавсралт:

1. “Эрсдэлийн удирдлагын хороо байгуулах тухай” ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 23/06 тоот тогтоол
2. “Компанийн засаглалын бодлого, хөтөлбөр, журам шинэчлэн батлах тухай” ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 23/07 тоот тогтоол, тогтоолын хавсралтууд
  - ✓ “Залгамж холбооны бодлого” нэгдүгээр хавсралт
  - ✓ “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр” хоёрдугаар хавсралт
  - ✓ “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам” гуравдугаар хавсралт
  - ✓ “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам” дөрөвдүгээр хавсралт
  - ✓ “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам” тавдугаар хавсралт
3. “Комплайнсын нэгж, ажилтан томилох тухай” ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 23/08 тоот тогтоол

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХЯНАСАН:  
ТУЗ-ИЙН ДАРГА



О.ОЮУНХҮҮ

Л.МӨНХНАРАН



## “УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 23/06

Улаангом сум

### Эрсдэлийн удирдлагын хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Эрсдэлийн удирдлагын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хорооны дарга: А.Чимид-Очир

Гишүүд: Н.Оюун

Л.Нямгэрэл

2. Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодекс, компанийн дүрэм, засаглалын дотоод журам болон бусад хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийг хороонд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.МӨНХНАРАН



## “УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 23/07

Улаангом сум

Компанийн засаглалын бодлого, хөтөлбөр, журам  
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.3 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн засаглалын бодлого, хөтөлбөр, журмыг дараах хавсралтаар баталсугай.

- 1.1 “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг нэгдүгээр хавсралтаар
- 1.2 “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийг хоёрдугаар хавсралтаар
- 1.3 “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг гуравдугаар хавсралтаар
- 1.4 “Гүйцэтгэх удирдлагын ажиллах журам”-ыг дөрөвдүгээр хавсралтаар
- 1.5 “Эрдэлийн удирдлагын хорооны ажиллах журам” тавдугаар хавсралтаар

2. Компанийн засаглалын бодлого, хөтөлбөр, журмыг ажилчдад таниулах, мэдээлэх ажлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (О.Оюунхүү)-д үүрэг болгосугай.

3. Компанийн засаглалын бодлого, хөтөлбөр, журмыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх хороод, Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.МӨНХНАРАН

“Увс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
23/07 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



## ЗАЛГАМЖ ХОЛБООНЫ БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү залгамж халааны бодлогын зорилго нь компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компанийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад оршино.
- 1.2 Эрх бүхий албан тушаалтан гэдэгт Монгол улсын компанийн тухай хуульд заасан албан тушаалтнууд хамаарна.
- 1.3 Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ГУЗ” гэх)-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх) нь энэхүү залгамж халааны бодлогыг боловсруулан, ГУЗ-өөр батлуулна.

### Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.2 Хороо нь эрх бүхий албан тушаалтнуудын сургалт, хөгжил, албан тушаал дэвшүүлэх, ажилтны ур чадварыг хөгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3 Хороо нь компанийн дотоод хүний нөөц болон гадна эх сурвалжаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.4 Захиргаа, хүний нөөцийн алба нь эрх бүхий албан тушаалтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө, албан тушаал дэвшүүлэх, чадварлаг ажилтнуудыг тодорхойлох, ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Хороонд танилцуулан саналыг тусган, ГУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.
- 2.5 Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Компанийн Захиргаа, хүний нөөцийн алба нь судалгаа боловсруулах, тайлан гаргах, хамтарсан төлөвлөгөө гаргах гэх зэргээр Хороотой бүхий л талаар хамтран ажиллана.
- 2.6 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсвэл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.7 Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.
- 2.8 Компанийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагаанаас хамааран эрх бүхий албан тушаалтны орон тоонд өөрчлөлт орох тохиолдолд Компанийн Захиргаа, хүний нөөцийн алба нь Хороонд хүргүүлж дүгнэлтийг авах бөгөөд ГУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулна.
- 2.9 Эрх бүхий албан тушаалтан нас барсан, цаашид хөдөлмөр эрхлэх чадваргүй болсон, бусад урьдчилан мэдэх боломжгүй, гэнэтийн нөхцөл байдлын улмаас ажиллах

боломжгүй, ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд Хороо нь эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.

2.10 Гүйцэтгэх удирдлага урт хугацаанд чөлөөтэй байх, ажиллах боломжгүй байх, өвчтэй байх тохиолдолд Гүйцэтгэх удирдлагыг орлон ажиллах этгээдийг Хорооны санал, дүгнэлтийг үндэслэн ТУЗ томилно.

2.11 Гүйцэтгэх удирдлагаас бусад компанийн дотоод бүтэц, нэгжид хамаарах эрх бүхий албан тушаалтан нас барсан, цаашид хөдөлмөр эрхлэх чадваргүй болсон, бусад урьчилан мэдэх боломжгүй, гэнэтийн нөхцөл байдлын улмаас ажиллах боломжгүй ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд орлон ажиллах этгээдийг Хорооны санал дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх удирдлага томилно.

### **Гурав. Хяналт сайжруулалт**


3.1 Энэхүү бодлого нь холбогдох журмуудын хэрэгжилтэд хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, түүнийг дагалдах залгамж халааны төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг хянах зорилгоор үнэлэлт дүгнэлт өгнө.

3.2 ТУЗ энэхүү бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдсон асуулт байвал холбогдох этгээдээс тодруулга авах, аливаа асуудал гарвал засаж залруулах бүрэн эрхтэй байна. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж эсэвэл холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагын дагуу уг бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

### **Дөрөв. Бодлогын талаар нийгэд мэдээлэл хүргэх тухай**

4.1 Компанийн тухай хууль, түүний хүрээнд батлагдсан журмууд, СЗХ-ны баталсан дүрэм, журам, тэдгээрийн шинэчилсэн хувилбар болон бусад хууль журмаар шаардсан тохиолдолд энэхүү бодлогын талаарх мэдээллийг компанийн жилийн тайланд оруулж, бодлогын баримт бичгийг компанийн цахим хуудсанд байршуулна.

### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

  
“УВС Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
28/07 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагчид компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү хөтөлбөрийг үр дүнд хэрэгжүүлэхийн тулд дараах зорилгыг ханган ажиллана.
  - 1.2.1 Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хувьцаа эзэмшигчдийг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах,
  - 1.2.2 Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх
  - 1.2.3 Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангах
  - 1.2.4 Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах.
- 1.3 Хөрөнгө оруулагчтай харилцахад дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 1.3.1 Мэдээлэл үнэн зөв байх,
  - 1.3.2 Хөрөнгө оруулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх,
  - 1.3.3 Компанийн дүрмийг баримтлах
- 1.4 Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомж, компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам зааварт нийцсэн байна.
- 1.5 Энэхүү хөтөлбөрт дурдсан дараах нэр томъёог дор дурдсанаар ойлгоно. Үүнд:
  - 1.5.1 “Хувьцаа эзэмшигч” гэж компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдийг,
  - 1.5.2 “Ирээдүйн хөрөнгө оруулагч” гэж хувьцаа, бонд зэрэг компанийн гаргасан үнэт цаасыг эзэмшигч болохыг сонирхож буй хувь хүн, хуулийн этгээдийг,

### **Хоёр. Хөрөнгө оруулагчтай харилцах**

- 2.1 Компани нь хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар хүргэнэ.
  - 2.1.1 Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан,
  - 2.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал,

- 2.1.3 Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл,
  - 2.1.4 Зэх зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт,
  - 2.1.5 Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал,
  - 2.1.6 Шаардлагатай бусад.
- 2.2 Нийтэд ил тод мэдээлэх, мэдээллээс бусад мэдээлэл болон хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээ хэлцлийн хүрээнд мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигчид хүргэх тохиолдолд албан ёсны цахим шуудангийн хаягаар, цаасан хэлбэрээр гарт нь эсхүл шуудангаар илгээнэ.
- 2.3 Компани нь дор дурдсан хэлбэрээр хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагчтай харилцана. Үүнд:
- 2.3.1 Хувьцаа эзэмшигчдын хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах,
  - 2.3.2 Санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах,
  - 2.3.3 Мэдээлэл хүргэх, солилцох
  - 2.3.4 Шаардлагатай бусад.
- 2.4 Хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагч нь санал, хүсэлт, гомдол гаргах тохиолдолд компанийн албан ёсны цахим шуудан ([info@uvskhuns.mn](mailto:info@uvskhuns.mn))-аар, цаасан хэлбэрээр, шуудангаар дамжуулан хүргүүлэх боломжтой бөгөөд шаардлагатай бусад байдлаар харилцах тохиолдолд албан бичгээр харилцана.

### **Гурав. Бусад**

- 3.1 Компанийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан ажиллана.
- 3.2 Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд компанийн ТУЗ-өөс хяналт тавина.
- 3.3 Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор компанийн ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



  
“Увс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
2307 тоот тогтоолын гуравдугаар хавсралт

## **НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДТЭЙ ХИЙХ ХЭЛЦЭЛ, СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам /цаашид журам гэх/-аар Увс Хүнс ХК /цаашид компани гэх/-ийн Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох Компанийн үйл ажиллагаан дах сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Компанийн засаглалын кодексе, Компанийн дүрэм, журмын хэлбогдох хэсгээс бүрдэнэ.
- 1.3 Журам нь ТУЗ баталснаар хүчин төгөлдөр үйлчлэх ба Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагаас баталсан дүрэм, журам, тогтоол шийдвэр, гэрээ хэлцэл энэхүү журамтай нийцсэн байна.

### **Хоёр. Нэгдмэл сонирхолтой этгээдийг тодохойлох**

- 2.1 Дараах этгээдийг нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ. Үүнд:
  - 2.1.1 Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран Компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс,
  - 2.1.2 Компанийн толгой, толгой болон компанийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан,
  - 2.1.3 Компанийн ТУЗ-ийн дарга гишүүд, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, албадын дарга нар зэрэг эрх бүхий албан тушаалтан,
  - 2.1.4 Энэхүү журмын 2.1.3-т заасан эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, зээ нар ах дүү, бусад төрөл, садангийн хүн, тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд,
  - 2.1.5 Өөрөө эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан,
  - 2.1.6 Уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан,
  - 2.1.7 Гүйцэтгэх захирлын шийдвэрээр худалдан авалт, тендерийн асуудал хариуцсан нэг удаагийн шинжтэй их хэмжээний хэлцэл хийх албан тушаалтан,
- 2.2 Энэхүү журмын 2.1-г хамаарах Компанийн эрх бүхий албан тушаалтан нь жагсаалтад дурдсан нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг дараах

хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, толгой, охин, хараат болон зэргэлдээ компанийн хуульч нарт үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй.

- 2.2.1 Журмын 2.1-т хамаарах одоогийн эрх бүхий албан тушаалтнууд энэ журам батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор
  - 2.2.2 Журмын 2.1-т заасан эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ
  - 2.2.3 Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтад өөрчлөлт орсоноос хойш ажлын 10 өдрийн дотор,
- 2.3 Компанийн холбогдох эрх бүхий албан тушаалтан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу төрийн эрх бүхий байгууллагад нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдүүлгээ мэдүүлсэн нь энэ журмын 2.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 2.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, толгой, охин, хараат, болон зэргэлдээ компанийн хуульч (ажлын байрны тодорхойлолтоор уг үүргийг хүлээсэн ажилтан) нар нь Компани болон Компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж, хэлцэл хийгдэхийн өмнө лавлагаа гаргаж өгч байх ба дараах албан тушаалтанд тухай бүрт нь танилцуулж, аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр болон хууль тогтоомжийн дагуу ил болгож болно.
- 2.4.1 Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа эзэмшигчид,
  - 2.4.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд,
  - 2.4.3 Гүйцэтгэгч захирал,
  - 2.4.4 Хуульч

### **Гурав. Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх**

#### **Сонирхлын зөрчилтэй хэлцэл**

- 3.1 Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол Компанитай, эсхүл түүний толгой, охин, хараат болон зэргэлдээ компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Үүнд:
- 3.1.1 Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа,
  - 3.1.2 Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа,
  - 3.1.3 Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа,
  - 3.1.4 Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа
- 3.2 Гүйцэтгэх захиралд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ. Уг асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн хараат

бус гишүүд заавал оролцоно. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг тухайн хэлцлийн хувьд сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн бол зөвшөөрөл олгоно.

- 3.3 Нэгдмэл сонирхолтой этгээдтэй сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх, хэлцлээр тохирох гэрээний нөхцөл, захиран зарцуулах хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг ТУЗ-ийн тогтоолд дурдсан байна.
- 3.4 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг тухайн хэлцлийн хувьд сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүд олонхийн саналаар дэмжээгүй тохиолдолд уг асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, хуралд оролцсон саналын эрхийн олонх дэмжсэнээр хэлцэл байгуулах зөвшөөрөл олгоно.
- 3.5 ТУЗ санал нэгтгэйгээр хэлцэл хийхийг дэмжиж зөвшөөрөл олгоогүй дараах тохиолдолд Компани нь энэ журамд заасан нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчилтэй бөгөөд их хэмжээний хэлцэл хийх, толгой, охин, хараат болон зэргэлдээ компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй Хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлүүлнэ.

Үүнд:

- 3.5.1 Компанийн тухай хуульд тодорхойлсны дагуу компанийн ТУЗ-өөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гарах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх,
- 3.5.2 Компанийн гарах энгийн эрхийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанид урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх,
- 3.5.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүн нь /хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн/ хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.

#### **Дөрөв. Компани дахь сонирхлын зөрчлийг зохицуулах**

- 4.1 Компанийн ТУЗ нь нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд дараах эрх, үүрэгтэй оролцоно. Үүнд:
  - 4.1.1 Компанийн бизнесийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд харшлахгүй, нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг үнэн зөвөөр мэдүүлсэн гэж үзвэл энэхүү журамд заасан хэлцэл хийх зөвшөөрөл олгох,
  - 4.1.2 Энэ журмын 3.4, 3.5-д заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлэх,
  - 4.1.3 Компанийн ТУЗ-ийн аль нэг гишүүнд хамааралтай “сонирхлын зөрчилтэй” хэлцэл хийх эсэх шийдвэрийг тухайн гишүүнийг оролцуулахгүйгээр ТУЗ шийдвэрлэх,
  - 4.1.4 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хэмжээ, үнэ, нөхцлийг тодорхойлох,
  - 4.1.5 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг, жагсаалтыг тухай бүрт нь авч бүртгэл хөтөлж, өөрчлөлтийг тусгаж байгаа эсэхэд хяналт тавих.

- 4.2 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, толгой, охин, хараат болон зэргэлдээ компанийн хуульч (эсхүл ажлын байрны тодорхойлолтоор уг үүргийг хүлээсэн ажилтан) нь компанид үүсч болох ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.2.1 Энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хүлээн авах
  - 4.2.2 Эрх бүхий албан тушаалтан нь хууль болон энэ журмаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд мэдүүлгийг хугацаанддаа өгөхийг шаардах, үүрэг болгох,
  - 4.2.3 Компани болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл хөтөлж, хэлцэл хийх үед лавлагаа гаргаж өгөх компанийн Захиргаа, хүний нөөцийн албаны даргад бүртгэлээ тухай бүр танилцуулах.
- 4.3 Компанийн Гүйцэтгэх захирал болон Хуульч (эсхүл ажлын байрны тодорхойлолтоор уг үүргийг хүлээсэн ажилтан) нь Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.3.1 Компанийн хуульч нь аливаа гэрээ, хэлцлийг хянахдаа Компанийн тухай хууль, энэхүү журамд тодорхойлсон сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байгаа эсэхийг хянах ба сонирхлын зөрчилтэй хэлцэл байж болзошгүй тохиолдолд хэлцэл хийх сонирхол бүхий байх магадлалтай эрх бүхий албан тушаалтан, эсхүл ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд мэдэгдэх,
  - 4.3.2 Шаардлагатай тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, цаашид үүсч болох эрх зүйн үр дагаврын талаар Компанийн ТУЗ-ийн хуралд зөвлөмж бэлтгэж танилцуулах,
  - 4.3.3 ТУЗ-өөс сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл гарсан тохиолдолд холбогдох хэлцлийг хууль тогтоомж, энэхүү журам болон хэлцэл байгуулах ерөнхий нөхцөлийг тодорхойлсон ТУЗ-ийн тогтоолд нийцүүлэн хянах, эсхүл төслийг боловсруулах,
  - 4.3.4 Гүйцэтгэх захирал нь сонирхлын зөрчилтэй байж болохуйц хэлцлийн талаар Компанийн ТУЗ-д мэдэгдэх, хуулийн хэлтсээс боловсруулсан гэрээ хэлцлийг хянах, ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд гэрээ байгуулж ажиллана.
- 4.4 Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ журмын 3.5-д заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.
- 4.5 Энэ журмын 2.1-т заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцогдохоос өмнө Компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал нь
- 4.6 Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх өдөр Компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран Компанийн буюу түүний толгой, охин, хараат болон

зэргэлдээ компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ журмын 3.5-д заасан шаардлагыг хангасанд тооцно.

#### **Тав. Журмын хяналт**


- 5.1 ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь жилд нэг удаа уг журмын биелэлтийг хянаж, үнэлэх бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шинэчлэх, өөрчлөлт оруулахыг ТУЗ-д санал оруулж болно.
- 5.2 Журамд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, толгой, охин, хараат болон зэргэлдээ компанийн хуульч нь өдөр тутам хяналт тавьж ажиллана.

#### **Зургаа. Хариуцлага**

- 6.1 Компанийн тухай хууль энэхүү журамд тодорхойлсны дагуу Нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (эсхүл ажлын байрны тодорхойлолтоор уг үүргийг хүлээсэн ажилтан)-д өгөөгүй, нэгдмэл сонирхолтой болохоо мэдэгдээгүйгээс, хууль тогтоомжоос гадуур сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан болох нь илэрсэн, үүнээс үүдэн компанид учирсан хохирлыг тухайн албан тушаалтан өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна. Түүнчлэн уг зөрчил гаргасан албан тушаалтныг сонгосон, томилсон эрх бүхий этгээд хугацаанаас өмнө чөлөөлөх шийдвэр гаргах эрхтэй.
- 6.2 Энэ журмын 6.1-т заасан этгээд нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцлийг компанийн тухай хууль, энэ журмын шаардлага, тогтоосон журмыг зөрчиж хийсний улмаас Компани буюу түүний толгой, охин, хараат болон зэргэлдээ компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.3 Энэ журмын 4.2-т заасан үүргээ бизелүүлээгүй ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, охин компанийн хуульч (эсхүл ажлын байрны тодорхойлолтоор уг үүргийг хүлээсэн ажилтан)-д Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 6.4 Өөрийн буруугаас Компанид хохирол учруулсан журмын 2.1-т заасан этгээдэд энэ журам болон бусад хуульд заасан хариуцлагыг оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэж болно.
- 6.5 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, эсхүл компани нь энэ журмын 2.1-т заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

#### **Долоо. Бусад**

- 7.1 Энэхүү журмаар зохицуулаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон холбогдох бусад журам, заавруудад заасны дагуу шийдвэрлэнэ.
- 7.2 Энэхүү журам нь ТУЗ-ийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байна.

  
“Увс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
28/07 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралт

## **ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг.Ерөнхий зүйл**

- 1.1 Увс Хүнс ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.
- 1.2 Компанийн гүйцэтгэх удирдлагаар (цаашид Гүйцэтгэх захирал гэх)хувь хүн ажиллах бөгөөд холбогдох хуулийн хүрээнд ажиллана. Гүйцэтгэх захирал нь энэ журам болон “Хөдөлмөрийн гэрээ”-нд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 1.3 Энэхүү журам нь Гүйцэтгэх захирлын бүрэн эрх болон түүнийг томилох чөлөөлөх, үүрэг хариуцлага, цалин урамшууллыг тодорхойлно.
- 1.4 Гүйцэтгэх захирал нь ажлаа ТУЗ-д тайлагнах ба ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг хэдийд ч гаргах эрхтэй.
- 1.5 ХЭХ болон ТУЗ-өөс гаргасан бүх шийдвэрийг Гүйцэтгэх захирал дагаж мөрдөнө.

### **Хоёр. Гүйцэтгэх захирлын статус**

- 2.1 Гүйцэтгэх захирал нь компанийн удирдлагын нэг гишүүн байна.
- 2.2 Гүйцэтгэх захирал компанийн ТУЗ-ийн гишүүн байх, мөн бусад аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагаар ажиллаж болно. ТУЗ-ийн дарга байж болохгүй.
- 2.3 Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас өөр ямар нэгэн арилжааны үйл ажиллагаанд оролцохгүй.
- 2.4 Гүйцэтгэх захирал, компанийн хоорондын харилцааг ТУЗ болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулсан “Хөдөлмөрийн гэрээ”-ээр зохицуулна.
- 2.5 Гүйцэтгэх захирал нь Компанитай сонирхлын зөрчил бүхий аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх ба хэрэв сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухай ТУЗ-д нэн даруй мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-өөс зөвшөөрөл авна.

### **Гурав. Гүйцэтгэх захирлын эрх**

- 3.1 ХЭХ болон ТУЗ-ийн эрхэд шууд харьяалагдахаас бусад үед компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулж явуулах бөгөөд ХЭХ болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 3.2 Үүрэгт ажилдаа албан ёсоор томилогдсоны дараа Гүйцэтгэх захирал нь баримт бичгүүдэд гарын үсэг зурах, тушаал, заавар гаргах, гэрээ хэлцлийг хэрэгжүүлэх, компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцлийг хуулийн дагуу байгуулах эрхтэй болно. Мөн Гүйцэтгэх захирал нь ажлын ачааллаас шалтгаалан хууль, тогтоомжид өөрөө заавал хэрэгжүүлэхээр зааснаас бусад тохиолдолд өөрийн зарим эрх хэмжээг эрх бүхий албан тушаалтнуудад шилжүүлж болно.
- 3.3 Гүйцэтгэх захирал нь:
  - 3.3.1 Компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлан итгэмжлэл авахгүй бөгөөд компанийн сонирхлыг төлөөлөх

- 3.3.2 Банк болон зээлийн байгууллагуудад төлбөр тооцооны данс нээх
- 3.3.3 Компанийн дүрмийн дагуу ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд компанийн хөрөнгийг өдөр тутмын үйл ажиллагаанд захиран зарцуулах
- 3.3.4 Өөрийн эрх мэдлийн хүрээнд компанийн ажиллагсдын үйл ажиллагаанд чиглэл өгч удирдах
- 3.3.5 Компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах итгэмжлэлийг олгох
- 3.3.6 Компанийн нэрийн өмнөөс хуулийн байгууллага болон хувь хүний эсрэг гомдол, нэхэмжлэл гаргах асуудлаар шийдвэр гаргах
- 3.3.7 ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авах, хөдөлмөрийн гэрээг цуцлах болон компанийн ажиллагсдын шагнал, урамшуулал оногдуулах арга хэмжээг шийдвэрлэх
- 3.3.8 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах
- 3.3.9 Компанийн санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх болон компанийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгчид болон зах зээлд мэдэгдэх асуудлыг зохион байгуулах
- 3.3.10 Компанийн санхүүгийн тайланд гарын үсэг зурж баталгаажуулах
- 3.3.11 Гүйцэтгэх захирлын ажлын талаарх тайланг ТУЗ-д улирал тутам танилцуулах ба үүнд компанийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг оруулах
- 3.3.12 Гүйцэтгэх захирлын ажлын тайланг ХЭХ-д жилд нэгээс доошгүй удаа гаргах
- 3.3.13 Жилийн болон хагас жилийн тайлан, компанийн ашиг, алдагдлын өгөгдөл тайлан болон компанийн үйл ажиллагаа, эрсдэлд нөлөөлж болох хүчин зүйлүүдийн илтгэлийг боловсруулж, ТУЗ-д хүргүүлэх
- 3.3.14 Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- 3.3.15 Компанийн стратеги (бизнес болон санхүүгийн) төлөвлөгөөний биелэлтийг хангах
- 3.3.16 Компанийн ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтын журмыг батлах
- 3.3.17 Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг эрх мэдлийнхээ хүрээнд тогтоох
- 3.3.18 ХЭХ болон ТУЗ-ийн хуралд шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулах
- 3.3.19 Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд менежменттэй холбоо бүхий бусад бүх асуудлаар шийдвэр гаргах
- 3.3.20 ХЭХ болон ТУЗ-ийг оролцуулан компанийн бусад нэгжүүдэд зохион байгуулалт, техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- 3.3.21 Компанийн хөрөнгө оруулсан байгууллагуудын Гүйцэтгэх захирал, хөндлөнгийн аудит, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх
- 3.3.22 Хуулийн дагуу компанийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бусад үйл ажиллагааг компанитай байгуулсан гэрээнд зааснаар эрхлэн явуулах

#### **Дөрөв. Гүйцэтгэх захирлыг томилох, бүрэн эрхийг цуцлах**

- 4.1 Хуульд заасны дагуу Гүйцэтгэх захиралд хэнийг ч томилж болно.
- 4.2 Гүйцэтгэх захиралд нэр дэвшигч нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна.
  - 4.2.1 Дээд боловсролтой, салбартаа 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай
  - 4.2.2 Бизнесийн туршлагатай, эдийн засаг, улс төр, эрх зүй, нийгмийн асуудлаар мэдлэгтэй

- 4.2.3 Компанийн сонирхогч талуудын ашиг сонирхлыг харгалзан үзэх, бодит шийдвэр гаргах чадвартай байх
- 4.2.4 Гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар томилно.
- 4.3 Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцлийг хуульд заасны дагуу ТУЗ тодорхойлно.
- 4.4 ТУЗ нь Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг гэрээнд заасан үндэслэлээр хэдийд ч цуцалж болох ба гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг цуцалсан буюу цуцлах тухай санал тавьсан тохиолдолд Гүйцэтгэх захирлыг шинээр сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

#### **Тав. Үүрэг, хариуцлага**


- 5.1 Гүйцэтгэх захирал нь компанийн болон түүний хувьцаа эзэмшигчдийн сонирхлын үүднээс шударгаар, зохих анхаарал тавьж ажиллана.
- 5.2 Гүйцэтгэх захиралд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 5.2.1 Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компанид ажиллах
  - 5.2.2 Компани болон ТУЗ-ийн гишүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох аливаа үйлдэлд оролцох
  - 5.2.3 Компанийн хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглах
- 5.3 Нийтэд нээлтгүй бус, нууц мэдээллийг хувийн сонирхол эсвэл гурав дахь талын сонирхлын үүднээс ашиглахгүй байх, ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан нууц буюу дотоод мэдээллийг энэхүү мэдээлэлд нэвтрэх боломжгүй хүмүүст мэдээлэхээс зайлсхийх
- 5.4 Компанийн мэдээлэл эсвэл бизнесийн боломжийг хувьдаа тухайлбал хувийн ашиг, орлого олох зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.
- 5.5 Гүйцэтгэх захирлаас гаргах шийдвэрт сонирхол бүхий этгээдээс үнэ цэнэтэй бэлэг сэлт авахгүй байх эсвэл шууд буюу шууд бус замаар ашиг хүртэхгүй байх ба энэ нь албан ёсны үйл ажиллагааны үеэр өгсөн бэлэг нь бэлгэдлийн чанартай, хэвшсэн сайн санааны үүднээс өгч байгаа эсвэл дурсгалын зүйл байвал үүнд хамаарахгүй.
- 5.6 ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийг компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын талаарх иж бүрэн, үнэн зөв, цагаа олсон мэдээллээр хангана.
- 5.7 Компанид хохирол учруулсан шийдвэрийг гаргах санал хураалтад эсрэг эсвэл түдгэлзсэн санал өгсөн Гүйцэтгэх захирал тэрхүү хохирлын хариуцлагыг хүлээхгүй.

#### **Зургаа. Цалин урамшуулал**

- 6.1 Гүйцэтгэх захирлын цалинг ТУЗ тогтооно.
- 6.2 Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал нь компанид ажилласан хугацаанаас хамаарах ба тогтмол болон урамшуулал хэсгээс бүрдэнэ.

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



  
“Увс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
22/07 тоот тогтоолын тавдугаар хавсралт

## **ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Увс Хүнс ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэхэд Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “Хороо” гэх)-ны чиг үүрэг, оролцоог тодорхойлох, Хорооны ажиллах зарчмыг тодорхойлоход оршино.

### **Хоёр. Хорооны гишүүнчлэл**

- 2.1 Хороо 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүд болон даргыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлын тогтоолоор томилно.
- 2.2 Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.3 Хорооны хоёроос доошгүй гишүүнийг хараат бус гишүүд байлгахыг зорих ба хорооны аль нэг гишүүн нь эдийн засаг эсвэл санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай байна.
- 2.4 Увс Хүнс ХК-ийн Гүйцэтгэх захирал нь Хорооны гишүүн байж болно.

### **Гурав. Хорооны нарийн бичгийн дарга**

- 3.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын нарийн бичгийн даргаар давхар ажиллана.
- 3.2 Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх буюу зохион байгуулалтын чиг үүргийг гүйцэтгэнэ.

### **Дөрөв. Хорооны хурал**

- 4.1 Хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Хороо нь жил бүрийн эхний улиралд багтан тухайн жилийн хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоон батална.
- 4.2 Увс Хүнс ХК-ийн эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр тухайн жилийн батлагдсан хуваарьт ороогүй хурлыг шаардлагатай тохиолдолд зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь Хороо хуралдуулах хүсэлтээ нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд нарийн бичгийн дарга нь Хороогоор хэлэлцүүлэх асуудлыг танилцуулга, холбогдох баримт бичгийн бүрдлийг шалгаж, шаардлага хангасан тохиолдолд Хорооны хурлыг товлон Хорооны гишүүд болон хүсэлт гаргасан эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.
- 4.3 Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын зарыг товлон өдрөөс ажлын 3 өдрийн өмнө цахим шуудангаар Хорооны гишүүд болон хуралд оролцох бусад этгээдэд илгээнэ.
- 4.4 Хорооны хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно. Цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд дуу, дүрсний бичлэг хийж хадгалах бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан цахим хурал зохион байгуулах журмыг мөрдөнө.

- 4.5 Хорооны хуралд Хорооны гишүүнээс бусад этгээд оролцох эрхгүй. ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн бусад гишүүд, Увс Хүнс ХК-ийн Гүйцэтгэх удирдлага, дотоод аудаторуудын төлөөлөл болон бусад этгээд Хорооны хуралд урилгаар оролцож болно.
- 4.6 Журмын 4.2 дахь заалтад заасны дагуу хуралдсан Хорооны хуралд хүсэлт гаргасан эрх бүхий албан тушаалтан оролцож, хэлэлцэх асуудлыг танилцуулна.
- 4.7 Хорооны хуралд хоёроос доошгүй гишүүд ирснээр хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 4.8 Хорооны хурлаас гарах бүх шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 4.9 Хорооны хурлаас дүгнэлт гарах бөгөөд дүгнэлтэд хуралд оролцсон Хорооны гишүүд гарын үсэг зурна.
- 4.10 Хорооны нарийн бичгийн дарга нь дүгнэлт гарснаас хойш хуанлийн 10 хоногийн дотор ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, дүгнэлтийг танилцуулан ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулна.
- 4.11 Хорооны нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд хурлын тэмдэглэлийг баталгаажуулах зорилгоор дууны болон дуу, дүрсний бичлэг хийн хадгалж болно.
- 4.12 Хорооны хурлыг цахим хэлбэрээр явуулах боломжтой. Энэ тохиолдолд цахим хурлын дуу, дүрсний бичлэгийг хадгалах бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан цахим хурал зохион байгуулах журмыг мөрдөнө.

#### **Тав. Хорооны бүрэн эрх**

- 5.1 Хороо нь дор дурдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 5.1.1 Компанийн эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих,
- 5.1.2 Гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн хөрвөх чадварын, үйл ажиллагааны хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавих,
- 5.1.3 Дотоод аудит компанийн эрсдэлийн удирдлагад хийсэн аудитын шалгалтын материалтай тухай бүр танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг ТУЗ-д өгч ажиллах
- 5.1.4 ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд зээл батлах буюу зээл олгох шийдвэр гаргах.

#### **Зургаа. Хорооны чиг үүрэг**

- 6.1 Дараах эрсдэлийн удирдлагатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана. Үүнд:
- 6.1.1 Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох, компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг хэлэлцэж ТУЗ-д танилцуулж батлуулах,
- 6.1.2 Дотоод хяналт, санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлагын системийн үр дүнгийн талаарх удирдлагын болон дотоод аудиторын тайланд дүгнэлт гаргах,
- 6.1.3 Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын талаар жилийн тайланд оруулсан тайлбарыг хянах
- 6.1.4 Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, шалгах зорилго бүхий удирдлагаас тогтоосон системийн далайц, үр дүнг дүгнэх,

- 6.1.5 Эрсдэлийн удирдлагын бодлого, журамд тодорхойлсон эрсдэлийн төрлүүдээр алдагдал, хохирлын түвшин хянах, компанийн эрсдэл даах чадварыг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хяналтын тогтолцооны найдвартай байдалд хяналт тавих,
- 6.1.6 Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны эрсдэлийн зөвшөөрөх хэмжээнд хяналт тавьж ажиллах.

#### **Долоо. Ажлын тайлан**

- 7.1 Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд, дотоод аудит, хөндлөнгийн аудит болон гүйцэтгэх захиралд хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн санал, дүгнэлтийг бүрэн тусгасан байна.
- 7.2 Хороо нь албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлагын дагуу хийсэн ажлаа ТУЗ-д улиралд нэгээс доошгүй удаа тайлагнана.
- 7.3 Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны үйл ажиллагаатай холбоотой компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгагдах мэдээллийг бэлтгэн тайлан гаргах чиг үүрэг бүхий албан тушаалтанд тухай бүрд нь гарган өгнө.

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



## “УВС ХУНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 23/08

Улаангом сум

### Комплайнсын нэгж, ажилтан томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалт, Комплайнсын бодлогын 3.1.2-т заасныг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналаар Баясгалангийн Сүнжидмааг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн Комплайнсын нэгж ажилтнаар томилсугай.
2. Хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлэн ажиллахыг (Б.Сүнжидмаа)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.МӨНХНАРАН